



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2017 оны 10 сарын 18 өдөр

Дугаар 60

Мандалговь

Хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 3 дахь заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:


1. Аймгийн засаг даргын тамгын газрын хөрөнгөнд бүртгэлтэй 19,901,361.63 төгрөгийн балансын үнэтэй 10,945,748.89 төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий дизель түлш үйлдвэрлэх тоног төхөөрөмжийг “Нийтлэг үйлчилгээ орон нутгийн өмчит үйлдвэрийн газар”-т балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Уг тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх талаар хувийн хэвшлийн аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах, түрээслэх гэт мэтээр тал бүрийн арга хэмжээ авч ажиллахыг Нийтлэг үйлчилгээ үйлдвэрийн газарт зөвшөөрсүгэй.

3. Хөрөнгийг зохих хууль журмын дагуу байгууллагын данс бүртгэлээс хасахыг аймгийн Засаг даргын тамгын газар /Ц.Эрдэнэсүрэн/-т, бүртгэж авахыг Нийтлэг үйлчилгээ үйлдвэрийн газар /Б.Наранцэцэг/-т тус тус даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ц.Мөнгөнцоожид үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

0100141